



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн
ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан*



**ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ОРЛОГЫН
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот
2014 он

Агуулга

<p>Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт 2</p>
<p>НАГ-ын дарга Б.Алтанзул</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл 3</p>
<p>Аудитын менежер З.Ариунзаяа</p>	<p>Бүлэг 1. Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн байдал 5</p>
<p>Шинжээч Б.Билэгт</p>	<ul style="list-style-type: none"> • ЭМДС-ийн хөрөнгөөр 2013 онд 147 арга хэмжээг 4.167,6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ 5
	<p>Бүлэг 2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар 6</p>
	<ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т заасан “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтыг биелүүлж ажиллаагүй байна 9
	<ul style="list-style-type: none"> • Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт зарцуулах санхүүжилтийн 60 хувийг олгосон байна 11
	<p>Бүлэг 3. Сангийн удирдлага, зохион байгуулалт болон тавих хяналтын талаар 14</p>
	<ul style="list-style-type: none"> • “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ийн зарим заалтыг биелүүлж ажиллаагүй байна 14
	<p>Дүгнэлт 15</p>
	<p>Холбогдох байгууллагын санал 16</p>
<p>2014 оны 10 дугаар сар</p>	<p>Зөвлөмж 18</p>
<p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.www.audit.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал 19</p>
<p>ХАЯГ: Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</p>	

Товчилсон үгийн жагсаалт

БГД	Баян гол дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
МУ	Монгол Улс
НАГ	Нийцлийн аудитын газар
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТББ	Төрийн бус байгууллага
ТХСК	Тамхины хяналтын суурь конвенци
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМДС	Эрүүл мэндийг дэмжих сан
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 3 дугаар тогтоол, ҮАГ-аас МУ-ын Ерөнхий Аудитор 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

ЭМДС-гийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, хуваарилалт зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт үр нөлөөтэй байгаа эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад ЭМЯ, Эрүүл мэндийг дэмжих сангийн ажлын Алба, тухайн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав.

Үүнд:

- ЭМДС-гийн орлогын бүрдүүлэлтийг түүвэрлэн шалгах;
- Холбогдох эрхийн актыг судлах;
- ЭМДС-гийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой судалгаанд дүн шинжилгээ хийх;
- ЭМДС-гаас бараа, ажил үйлчилгээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу худалдан авсан эсэхийг түүвэрлэн шалгасан болно.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий мэдээлэл

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам”-д заасны дагуу дараах эх үүсвэрээс бүрдэж байна.

Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө;
- Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;
- Гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгө;
- Архи согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь;
- Эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгө.

Сангийн удирдлага нь орон тооны бус 11 хүний бүрэлдэхүүнтэй Сангийн зөвлөлтэй бөгөөд сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж хариуцан гүйцэтгэдэг байна.

Тус зөвлөл нь үйл ажиллагаандаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг удирдлага болгодог байна.

Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам”-д заасны дагуу ЭМДС-ийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулдаг байна. Үүнд:

- Тамхи, архины болон эмийн зохисгүй хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах эрүүл мэндийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Тамхи, архины хор хөнөөлтэй тэмцэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах, хяналт тавих;
- Тамхи, архинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх;
- Тамхи, архинаас гаргах эмчилгээ болон түүнд шаардлагатай эм, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх;
- Тамхи, архины болон эмийн зохисгүй хэрэглээнээс хүн амын эрүүл мэнд, эдийн засагт учрах хор холбогдлыг судлах;
- Архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажилд идэвхтэй оролцож үр дүнд хүрсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааг дэмжих;
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах бусад үйл ажиллагааг дэмжих;
- Нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх;
- Нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;
- Эмнэлгийн мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн захиалгаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

- Анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах зэрэг болно.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар ЭМДС-ийн 2013 оны үйл ажиллагаанд зориулж 3,989.4 сая төгрөг батлагджээ.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн 2013 оны үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн хуваарилалт, зардлын жишгийг батлан хэрэгжүүлсэн байна.

Дахин Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 422 тоот тушаалаар Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.3 дугаар заалт, 2012 оны 123 тоот тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 324 дүгээр тогтоол, Эрүүл мэндийг дэмжих сангийн 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн тодотгол хийх болсонтой холбогдуулан 162 тоот тушаалаар баталсан 195.4 сая төгрөгийн нийт 14 арга хэмжээ хасагдсан байна.

Сангийн хөрөнгөөр 2013 оны гүйцэтгэлээр 127 төсөл арга хэмжээг 2,233.2 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Сангийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр гаргаж санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлдэг байна.

БҮЛЭГ 1. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАЙДАЛ

1.1 Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийг дэмжих сан (ЭМДС)-гийн зөвлөлийн даргын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх 147 арга хэмжээг 4.167,6 сая төгрөгийн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

1.2 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 257 тоот тушаалаар Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.3 дугаар заалт, 2012 оны 123 тоот тогтоол Сангийн зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн баталжээ. Үүнд:

ЭМД сангийн 2013 оны үйл ажиллагааны чиглэл дэх орон нутгийн ЭМГ-аас эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх хөрөнгийн хуваарилалт мөн орон нутагт зохион байгуулах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тус тус баталсан байна.

Орон нутагт зарцуулах хөрөнгийн хуваарилалтыг хүснэгтээр үзүүлбэл: сая.төг

Д/д	Аймгийн нэрс	Хүн амын тоо	Нийт дүн
1	Архангай	84765	30.5
2	Баян-Өлгий	89642	32.3
3	Баянхонгор	77249	27.8
4	Булган	54333	19.6
5	Говь-Алтай	53335	19.2
6	Дорноговь	60754	21.9
7	Дорнод	70745	25.5
8	Дундговь	37750	13.6
9	Завхан	64422	23.2
10	Өвөрхангай	101686	36.6
11	Өмнөговь	64400	23.2
12	Сүхбаатар	52214	18.8
13	Сэлэнгэ	101392	36.5
14	Төв	86262	31.0
15	Увс	73404	26.4
16	Ховд	77785	28.0

17	Хөвсгөл	116790	42.0
18	Хэнтий	66957	24.1
19	Дархан-Уул	96974	34.9
20	Орхон	92159	33.2
21	Говьсүмбэр	14084	5.1
22	Улаанбаатар	1302615	468.9
	Нийт	2839717	1022.3

Орон нутагт зохион байгуулах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Аймаг	Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл
1	Архангай	Халдварт бус өвчин (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын тогтолцооны өвчин)
2	Баян-Өлгий	Эхийн эрүүл мэнд, перинатал эндэгдлийг бууруулах
3	Баянхонгор	Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйл
4	Булган	Архинаас үүдэлтэй эмгэг, гэмтэл бэртлээс сэргийлэх
5	Говь-Алтай	Орчны эрүүл мэнд, усан хангамж ариун цэврийг сайжруулах
6	Дорноговь	БЗДХ-тай тэмцэх
7	Дорнод	БЗДХ-тай тэмцэх
8	Дундговь	Зүрх судасны өвчний эрсдэлийг бууруулах
9	Завхан	Хавдраас сэргийлэх
10	Өвөрхангай	5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, нярайн эрүүл мэнд
11	Өмнөговь	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг
12	Сүхбаатар	5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, нярайн эрүүл мэнд
13	Сэлэнгэ	Хавдраас сэргийлэх
14	Төв	5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, нярайн эрүүл мэнд
15	Увс	Хавдрын эрт оношлогоо, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах
16	Ховд	Архи тамхитай тэмцэх
17	Хөвсгөл	Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах
18	Хэнтий	Зоонозын халдварт өвчнөөс (бруцеллез) сэргийлэх, хариу арга хэмжээ
19	Дархан-Уул	Халдварт өвчин (Сүрьеэтэй тэмцэх, хариу арга хэмжээ)
20	Орхон	Дотоод шүүрлийн эмгэг
21	Говьсүмбэр	Зүрх судасны өвчний
22	Улаанбаатар	Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулах

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 тоот тушаалаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн 2013 оны үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн хуваарилалт, зардлын жишгийг батлан хэрэгжүүлэхээр төлөвлөн Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар ЭМДС-ийн 2013 оны үйл ажиллагаанд зориулж 3,989.4 сая төгрөг батлагджээ.

2.2 Сангийн хөрөнгөөр 2013 оны гүйцэтгэлээр 127 төсөл арга хэмжээг 2,233.2 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Мөн 6 үйл ажиллагааны 60 хувийн санхүүжилтийг олгож тэдгээр байгууллагуудаас 2014 оны 5 дугаар сарын 30-ны дотор гүйцэтгэлийн тайлан авахаар 230.4 сая төгрөгийн авлага үүсгэн гэрээ байгуулж, ажиллагчидтай холбогдсон зардал 5.4 сая төгрөг бөгөөд нийт 2,469.0 сая төгрөг зарцуулжээ.

Хөрөнгийн зарцуулалтыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Сангийн хөрөнгийг зарцуулах нөхцөлийн дагуу	Төсөв	Зарцуулалт	Зөрүү	Тайлбар
1	Тамхи, архины болон эмийн зохисгүй хэрэглээний хяналт, эрүүл мэндийг дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг дэмжих	2,649,159,000	1,384,976,006	1,264,182,994	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 176,900,000 төгрөг тодотголоор хасагджээ. "Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай" 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 1,087,282,994 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
2	Тамхи, архинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх болон хүн амын эрүүл мэндийг хамгаалах бусад үйл ажиллагааг дэмжих	132,200,000	96,903,400	35,296,600	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 6,000,000 төгрөг тодотголоор хасагджээ. "Монгол Улсын 2013 оны

					төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 29,296,600 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
3	Тамхи архины хор хөнөөлтэй тэмцэх талаар мсс явуулах хяналт тавих, тамхи, архинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өрнүүлэх	114,000,000	96,452,500	17,547,500	“Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 17,547,500 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
4	Тамхи, архины болон эмийн зохисгүй хэрэглээнээс хүн амын эрүүл мэнд, эдийн засагт учрах хор холбогдлыг судлах	39,500,000	38,970,000	530,000	“Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 530,000 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
5	Архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх	39,030,000	19,557,000	19,473,000	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 4,000,000 төгрөг тодотголоор хасагджээ. “Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 15,473,000 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
6	Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажилд идэвхитэй оролцож үр дүнд хүрсэн төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааг дэмжих	100,000,000	98,900,000	1,100,000	“Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 1,100,000 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
7	Нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх, нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлын талаар мсс явуулах	50,000,000	41,700,400	8,299,600	“Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 8,299,600 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
8	Орон нутгийн захиалгаар эмнэлгийн мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх, төсөл арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	80,398,000	36,288,220	44,109,780	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 4,500,000 төгрөг тодотголоор хасагджээ. “Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 39,609,780 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
9	Анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих	360,000,000	237,550,835	122,449,165	“Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 122,449,165 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
10	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг	608,330,000	411,921,820	196,408,180	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 4,000,000 төгрөг тодотголоор хасагджээ. “Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоол гарсны дагуу үлдэгдэл 192,408,180 төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
	Нийт	4,172,617,000	2,463,220,181	1,709,396,819	

2.3 Мөн 2013 оны 8 дугаар сараас эхлэн улсын төсвийн орлого бүрдээгүйгээс сангийн төлөвлөсөн үйл ажиллагааны санхүүжилт зогссон бөгөөд Сангийн яам 2013 оны 12 сарын 25-нд 631.0 сая төгрөгийн эрхийг нээжээ. Үүнд: хэрэгжсэн үйл ажиллагааны үлдэгдэл болон хэрэгжихээр бэлтгэгдсэн зургаан үйл ажиллагааны 60 хувийн санхүүжилтийг олгож тэдгээр байгууллагуудаас 2014 оны 05 сарын 30-ны дотор тайлан авахаар авлага үүсгэн гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т¹ заалтыг зөрчжээ.

Хүснэгт 2: авлага үүсгэлт

№	Сангийн хөрөнгийг зарцуулах нөхцөлийн дагуу	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	1.2.13.3 заалт Охид эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн мэдлэг олгох цогц арга хэмжээг зохион байгуулах	50,000,000	27,750,000	22,250,000	1.2.13.3 заалт Охид эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн мэдлэг олгох цогц арга хэмжээг зохион байгуулахад 27,750,000 төгрөгийн санхүүжилтийг 2013 оны 12 сарын 17-нд олгосноор үйл ажиллагааг 2014 оны 05 сарын 30-ны дотор дуусгаж тайланг хүлээлгэн өгөхөөр болсон.
2	1.2.13.1 заалт Нийгмийн эрүүл мэндийн нээлттэй форум зохион байгуулах	70,000,000	39,000,000	31,000,000	1.2.13.1 заалт Нийгмийн эрүүл мэндийн нээлттэй форум зохион байгуулахад зориулж 39,000,000 санхүүжилтийг 2013 оны 12 сарын 24-нд олгосноор үйл ажиллагааг 2014 онд хэрэгжүүлж тус оны 05 сарын 30-ны дотор дуусгаж тайланг хүлээлгэн өгөхөөр болсон.
3	8.3 заалт Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг чадавхижуулах богино хугацааны бүсчилсэн сургалт зохион байгуулах	45,000,000	12,000,000	33,000,000	8.3 заалт Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг чадавхижуулах богино хугацааны бүсчилсэн сургалт зохион байгуулахад зориулж 12,000,000 санхүүжилтийг 2014 оны 12 сарын 25-нд олгож үйл ажиллагааг 2014 онд хэрэгжүүлж тайланг 2014 оны 05 сарын 30-ны дотор хүлээлгэн өгөхөөр болсон.
4	10.4 заалт Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр хийх ажилд зарцуулагдах зардал (ёс зүйн хяналтын болон салбар хорооны хурал, шалгалт, үнэлгээ, баримт бичгийн боловсруулалт, сургалт зохион байгуулах	146,000,000	87,600,000	58,400,000	10.4 заалт Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр хийх ажилд зарцуулагдах зардал (ёс зүйн хяналтын болон салбар хорооны хурал, шалгалт, үнэлгээ, баримт бичгийн боловсруулалт, сургалт зохион байгуулахад 87,600,000 санхүүжилтийг 2013 оны 12 сарын 25-нд олгож үйл ажиллагааг 2014 онд хэрэгжүүлж, тайланг 2014 оны 05 сарын 30-нд хүлээлгэн өгөхөөр болсон.
5	10.8 эрүүл мэндийн салбарын багц хуулийн үзэл баримтллыг танилцуулан, хууль батлуулахад дэмжлэг авах арга хэмжээг зохион байгуулах	45,000,000	43,000,000	2,000,000	10.8 эрүүл мэндийн салбарын багц хуулийн үзэл баримтллыг танилцуулан, хууль батлуулахад дэмжлэг авах арга хэмжээг зохион байгуулахад 43,000,000 төгрөгийн санхүүжилт олгож тайланг 2014 оны 05 сарын 30-нд авахаар гэрээ хийсэн.
6	10.9 заалт Эрүүл мэндийн тухай хуулинд орох өөрчлөлтийг орон даяар хэлэлцүүлэх хэлэлцүүлэг зохион байгуулах	35,000,000	21,000,000	14,000,000	10.9 заалт Эрүүл мэндийн тухай хуулинд орох өөрчлөлтийг орон даяар хэлэлцүүлэх хэлэлцүүлэг зохион байгуулахад зориулж 21,000,000 санхүүжилтийг олгож 2014 оны 05 сарын 30-нд тайлан авахаар болсон.
Нийт		391,000,000	230,350,000	160,650,000	

¹ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах гэсэн

2.4 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 422 тоот тушаалаар Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.3 дугаар заалт, 2012 оны 123 тоот тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 324 дүгээр тогтоол, Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрүүл мэндийг дэмжих сангийн 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн тодотгол хийх болсонтой холбогдуулан үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс нийт 195.4 сая төгрөгийг хасжээ.

Хүснэгт 3: 422 тоотын хасалт

№	Сангийн хөрөнгийг зарцуулах нөхцөл	Хасалт	Тайлбар
1	Тамхи, архины болон эмийн зохисгүй хэрэглээний хяналт, эрүүл мэндийг дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг дэмжих	176,900,000	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 176,900,000 төгрөгийн тодотгол хийгдсэн.
2	Тамхи, архинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх болон хүн амын эрүүл мэндийг хамгаалах бусад үйл ажиллагааг дэмжих	6,000,000	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 6,000,000 төгрөгийн тодотгол хийгдсэн.
3	Архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх	4,000,000	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 4,000,000 төгрөгийн тодотгол хийгдсэн.
4	Орон нутгийн захиалгаар эмнэлгийн мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх, төсөл арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	4,500,000	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 4,500,000 төгрөгийн тодотгол хийгдсэн.
5	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг	4,000,000	Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаалаар 4,000,000 төгрөгийн тодотгол хийгдсэн.
	Нийт	195,400,000	

2.5 ЭМС-ын 162 тоот тушаалын 1.2.13.2-т заасан “Орон нутгийн ЭМГ-ын эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээнд хасалт хийжээ. Үүнд: Аймгуудын эрүүл мэндийн газарт зарцуулах хөрөнгөнөөс 21 аймгийн хүрээнд 55.2 сая төгрөг, Нийслэлийн эрүүл мэндийн газар болон харьяа байгууллагуудад зарцуулах хөрөнгөнөөс 44.8 сая төгрөг буюу нийт 100.0 сая төгрөгийг хасжээ.

2.6 Аудитын явцад шалгаж үзэхэд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт зарцуулах хөрөнгөнөөс 21 аймагт хуваарлах санхүүжилтийн 60 хувь буюу 374.2 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилаж, нийт 530 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Дутуу олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулсан болно.

сая.төг

Д/д	Аймгийн нэрс	Төсөв	Хасалт-422	Гүйцэтгэл	Зөрүү
1	Архангай	30.5	3.1	21	6.4
2	Баян-Өлгий	32.3	3.3	19.4	9.6
3	Баянхонгор	27.8	2.8	19.5	5.5
4	Булган	19.6	2	14.8	2.8
5	Говь-Алтай	19.2	0.2	19	0
6	Дорноговь	21.9	2.3	15.3	4.3
7	Дорнод	25.5	2.6	16.8	6.1
8	Дундговь	13.6	1.4	10.4	1.8
9	Завхан	23.2	2.4	16.1	4.7
10	Өвөрхангай	36.6	3.7	25.6	7.3
11	Өмнөговь	23.2	2.4	16.1	4.7
12	Сүхбаатар	18.8	1.9	14.4	2.5
13	Сэлэнгэ	36.5	3.7	21.9	10.9
14	Төв	31	3.1	24	3.9
15	Увс	26.4	2.7	15.8	7.9
16	Ховд	28	2.8	16.8	8.4
17	Хөвсгөл	42	4.2	25.3	12.5

18	Хэнтий	24.1	2.5	14.4	7.2
19	Дархан-Уул	34.9	3.5	24	7.4
20	Орхон	33.2	3.4	19.9	9.9
21	Говьсүмбэр	5.1	0.6	3.5	1
22	Улаанбаатар	448.9	44.8	0	404.1
	Нийт	1002.3	100	374.2	530.0

2.7 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 423 тоот тушаалаар Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.3 дугаар заалт, 2012 оны 123 тоот тогтоол, Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн “Сангийн хөрөнгө хувиарлах тухай” 162 дугаар тушаалын үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан дараах арга хэмжээг баталжээ. Үүнд: “Залуус-21” Алкоголгүй диско клуб байгуулах үйл ажиллагаанд Эрүүл мэндийг дэмжих сангаас хөрөнгө гаргах болсонтой холбогдуулан 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс 18 арга хэмжээний нийт 200 сая төгрөгийн хасалт хийжээ.

2.8 2013 оны төлөвлөгөөнөөс хассан дээрх үйл ажиллагааны санхүүжилтийг “Залуус-21” Алкоголгүй диско клуб байгуулахад зориулсан байна.

Хассан арга хэмжээний жагсаалт /сая.төг/

№		Үйл ажиллагаа	Төсөв	Нийт
1	1.2.2.1	Хүүхдийн шүдний кабинетийн иж бүрдэлээр зарим аймгийн нэгдсэн эмнэлгийг хангах	4.0	50.5
2	1.2.2.4	"Амны хөндийн эрүүл мэнд, шүд цооролтоос сэргийлэх талаар ТВ -ийн сурталчилгаа нэвтрүүлэг зохион байгуулах	9.0	
3	1.2.5.1	Осол гэмтлийн тандалтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аймгуудын дүн бүртгэгч эмч нарын сургалт зохион байгуулах	15.0	
4	1.2.5.2	Ослын дараах тусламж үйлчилгээ эрэмбэлэлтийн талаар эрүүл мэндийн ажилтанд зориулсан гарын авлага удирдамж боловсруулж хэвлүүлэх	6.0	
5	1.2.6.1	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний асуудлаар дэлхийн тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх (олон улсын байгууллагуудын дэмжлэг авдаггүй чиглэлүүд)	10.0	
6	1.2.13.3	Эрүүл хотод амьдарцгаа нийслэлийн зөвлөгөөн	3.5	
7	1.2.15.5	Иргэдэд зориулсан эмийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалын хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх	3.0	
8	2.3.2	Тамхины хяналтын хууль, ТХСК-ийн хэрэгжилт хурал зохион байгуулах, ТХСК-ийн татварыг төлөх	5.0	55.0
9	2.4.1	"Тамхи, архины хяналт, сэтгэцийн эрүүл мэндийн хуулийг хэрэгжүүлэхэд орон нутгийн байгууллагуудын чадавхийг сайжруулах бүсчилсэн семинар зохион байгуулах	45.0	
10	2.5.1	Тамхинаас гаргах арга, эмчилгээ" донтолтын эмч нарын сургалт	5.0	
11	3.1.1	Тамхины хяналтын бүхий л арга хэмжээнд УИХ-ын эмэгтэй гишүүдийн бүлгийн оролцоог хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	20.0	30.0
12	3.1.8	Тамхины хяналтын тухай хууль, журам, үндэсний стандартыг хэрэгжүүлэх нь сэдэвт уулзалт-хэлэлцүүлэгийг зохион байгуулах	5.0	
13	3.1.11	Тамхины холбогдолтой стандартуудын хэрэгжилтийг хэвлэл мэдээллээр сурталчилах	5.0	
14	4.1	Антибиотик эмэнд бүртгэлийн дараах судалгаа хийх	19.5	19.5
15	5.3	Архины асуудалтай хүн, түүний гэр бүлийнхэнд сэтгэл зүйн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээг аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нийгмийн үйлчилгээний төвүүдээр үзүүлэх, сургалт явуулах.	5.0	10.0
16	5.6	Архины хордлого тайлах, эмчилгээ, үйлчилгээний удирдамж боловсруулах	5.0	
17		Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үндэсний хэмжээний үнэлгээний дүнд үндэслэн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх уулзалтыг зохион байгуулах	5.0	
18	10.2	Эрүүл мэндийн ажилтны ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийж , эрүүл ажлын байр бүрдүүлэх цогц арга хэмжээ зохион байгуулах	30.0	35.0
19	10.7	Эрүүл мэндийн ажилтны ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийж , эрүүл ажлын байр бүрдүүлэх цогц арга хэмжээ зохион байгуулах	30.0	
19		ЭМСайдын 423 дугаар тушаалаар “Залуус-21” клуб байгуулахтай холбогдуулан хассан 18 арга хэмжээний дүн		200

Сангаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дурьдвал:

Гадаад сургалт:

2.9 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалын 9.2-т заасан “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх гадаад сургалт” гэсэн заалтын дагуу БНСУ-д 19 хүн, БНТУ-д 6 хүн, Япон улсад 11 хүн нийт 44 хүнийг сургалтад хамруулж сангаас 2013 онд нийт 198,7 сая төгрөгийг зарцуулжээ.

2.10 Мөн ЭМЯ-ны ТНБ-ийн даргын 2013 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 293 тоот тушаалаар Япон улсын Засгийн газраас Азийн орнуудын эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр Нагоягийн их сургуульд хэрэгжүүлж буй симпозиумд 1 хүнийг оролцуулж ЭМДС-аас 3.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ.

“Залуус - 21” алкогольгүй диско төв:

2.11 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 423 дугаар тушаалаар “Залуус-21” Алкоголгүй диско клуб байгуулах үйл ажиллагаанд Эрүүл мэндийг дэмжих сангаас хөрөнгө гаргахаар баталжээ.

- 2.12 Эрүүл идэвхитэй амьдралын клуб ТББ
- Өсвөр залуу үеийг архи, тамхины хамааралд өртүүлэхгүй байх урьдчилан сэргийлэх, амьдралын зөв хэвшилд сургах,
 - Архины хор хөнөөлийг нийгэм хамт олонд сурталчлах,
 - Архидан согтуурахтай тэмцэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулах
 - Баяр ёслолыг согтууруулах ундаа хэрэглэхгүй тэмдэглэх хэвшилд сургах,
 - Эрүүл мэндээ хамгаалах олон талт сургалт сурталчилгааг зохион байгуулах зорилготой “Залуус-21” алкогольгүй диско төвийг БГД-ийн 11-р хороонд байгуулжээ.



Эрүүл мэндийн салбарын багц хуулийн үзэл баримтлалыг танилцуулан хууль батлуулахад УИХ-ын гишүүдээс дэмжлэг авахад хийгдэх ажилд зориулан ЭМД сангаас хөрөнгө гаргажээ.

2.13 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалын 10.8-т заасан “УИХ-ын гишүүдэд чиглэсэн эрүүл мэндийн салбарын багц хуулийн үзэл баримтллыг танилцуулан, хууль батлуулахад дэмжлэг авах нөлөөллийн арга хэмжээ” гэсэн заалтын дагуу 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн ЭМС-ын баталсан удирдамжаар ЭМДС-аас 43.0 сая төгрөгийн санхүүжилтийг авлага үүсгэн 2013 оны 9 дүгээр сарын 3-нд Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэнд олгосон байна.

Сангаас шагнал, урамшуулал олгосон байна

2.14 ЭМС-ын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалын 1.2.4.5-т заасан “Эхэд ээлтэй хамт олон эрүүл мэндийн байгууллага шалгаруулж урамшуулал олгох” гэсэн заалтын дагуу ЭМС-ын 2013 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 107 дугаар тушаалаар Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгийн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Булган, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Увс аймгийн Эрүүл мэндийн газар тус бүрт 2.5 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгосон байна.

2.15 Мөн ЭМС-ын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалын 1.1.4 -т заасан “Гэнэтийн болон онцгой байдал, яаралтай арга хэмжээний нөөц зардал” гэсэн заалтын дагуу ЭМС-ын 2013 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 109 дүгээр тушаалаар Улсын клиникийн төв эмнэлэг болон Булган, Ховд аймгийн Эрүүл мэндийн газруудад нийт 1.2 сая төгрөгийн шагнал, урамшуулалыг ЭМДС-аас 2013 оны 10 дугаар сарын 4-ний өдөр олгосон байна.

Эрүүл мэндийн ажилтны цалин, урамшуулал, ажлын ачаалал, хөдөлмөрийн норм, нормчлолыг шинэчлэн тогтоох судалгаа:

2.16 Эрүүл мэндийн ажилтны цалин хөлсний өнөөгийн тогтолцоо, хөдөлмөрийн норм, норматив, ажлын ачаалал, ур чадварт суурилсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн нотолгоог гаргах зорилготойгоор судалгааг хийжээ. Судалгаанд хамрагдсан нийт 687 эмнэлгийн мэргэжилтнүүдийн 55.6 хувь нь их эмч, 26.1 хувь нь сувилагч, багийн бага эмч, эх баригч, 12.1 хувь нь лаборант, техникч, 6.3 хувь нь бусад төрлийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд байжээ.

2.17 Энэхүү судалгааны товч тайлан ЭМШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж зөвшөөрөгджээ. Судалгааг ЭМШУИС-ийн НЭМС удирдан ажилласан ба нийт 86 судлаач 12 баг болж ажилласан бөгөөд богино хугацаанд чанартай хийгдсэн судалгаа болсон гэж эрдэмтэд дүгнэсэн байна.

ЭМДС-ийн орон нутаг дах үйл ажиллагааны талаар

2.18 ЭМС-ын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалын 1.2.13.2-т заасан “Орон нутгийн ЭМГ-ын эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэсэн заалтын дагуу аймгийн Эрүүл мэндийн газруудад нийт 374.2 сая төгрөгийг ЭМДС-аас олгосон байна.

Аудитын хийх явцад олон нутагт гарсан зөрчлүүдийг дурдвал:

2.19 Баянхонгор аймагт: Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан атлаа заримыг нь ашиглаагүй, аймгаас зохион байгуулсан чуулганы төлөөлөгчдөд өгсөн номын үнийг сангийн мөнгөнөөс төлсөн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32.1, “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ын 1.2 заалтуудыг зөрчжээ.

2.20 Говь-Алтай аймагт:

- Үйл ажиллагааны төлөвлөгөөг нотлох баримтгүй, ЭМЯ-аас баталсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг харгалзахгүйгээр хийсэн байна.
- Санхүүжүүлсэн эх үүсвэрээс үндсэн баримтгүй 1561.5 мянган төгрөг шилжүүлсэнд санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон байна.

2.21 Төв аймагт: Эрүүл мэндийг дэмжих сангийн хүрээнд явагдаж байгаа аливаа ажлын холбогдох зардлын ихэнх хувийг уралдаан тэмцээний шагнал, хоол цай, томилолтын зардалд зарцуулсан ба сангийн хөрөнгөөс зориулалт бусаар шатахууны зардал гаргасан байна.

2.22 Орхон аймагт: “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн төлөвлөлт хуульд нийцээгүй, зарцуулсан хөрөнгөнд санхүүгийн хяналт хангалтгүй байна” гэсэн дүгнэлтийг хийжээ.

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

/ мянган төгрөгөөр/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
04/21	ЭМДСангийн хөрөнгөөр проектор худалдан авсан анонс хэвлүүлсэн	ЭМГ	Дарга Нягтлан бодогч	Г.Ганхуяг Г.Саулегуль	2565,0	
02/19	Эмаль шүдний эмнэлэгт эмчилгээний зардал илүү олгосон	ЭМГ	НЭМХ-ийн дарга Нягтлан бодогч	Ю.Алтантуяа Г.Саулегуль	462,0	
	Эрүүл амьдралын хэвшилд архам архмаар МСС-ны аянд шалгарсан 2 иргэнд өгөх өргөмжлөлийг зах зээлийн үнээс илүү бодож шилжүүлсэн	ЭМГ	НЭМХ-ийн дарга Нягтлан бодогч	Ю.Алтантуяа Г.Саулегуль	76,0	
01/18	Эрүүл мэндээ дээдлэгч өрх, иргэнийг шалгаруулах хөтөлбөрт нийт 5өрх, Зиргэн шалгарч шалгарсан иргэдийн шагналын мөнгийг бэлнээр зарлагадан авч батлагдсан зардалаасаа дутуу олгосон	ЭМГ	НЭМХ-ийн дарга Нягтлан бодогч	Ю.Алтантуяа Г.Саулегуль	504,0	
07/62	Халварт ба халдварт бус өвчнөөс болон урьдчилан сэргийлэх гарын авлага сонин зэргийг хүлээн авсан бүртгэл үйлдээгүй, иргэнд өгсөн шагналын нотлох баримтын бүрдэл хангалтгүй ЭМДСангийн 2013 оны үлдэгдэл болох 6590,0 мянган төгрөгнөөс 2014 онд шүдний эмнэлэгт шилжүүлэн олгосон, сангийн дансны үлдэгдэлийг шийдвэргүй зарцуулсан .	ЭМГ	Дарга Нягтлан бодогч	Г.Ганхуяг Г.Саулегуль		11844,1
Нийт дүн					3607,0	11844,1

БҮЛЭГ 3. САНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН ТАВИХ ХЯНАЛТЫН ТАЛААР

3.1 3Г-ын 2012 оны 123 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ЭМДС-ийн дүрмийн 3 дугаар заалтын 3.1-т “Сангийн удирдлага нь орон тооны бус Сангийн удирдах зөвлөл байх бөгөөд сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрх олгосон холбогдох нэгж хариуцан гүйцэтгэнэ” гэж заажээ.

3.2 2013 онд ЭМДСан 40 гаруй ТББ, холбоо, нийгэмлэгтэй хамтран төлөвлөгдсөн үйл ажиллагааны дагуу хамтран ажиллах гэрээ байгуулж, иргэдэд архи, тамхины хор нөлөө, эмийн зохисгүй хэрэглээний хяналт, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулжээ.

3.3 Аудитын явцад Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 162 дугаар тушаалын дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хамтран ажиллах төрийн бус байгууллагуудыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ЭМДС-ийн удирдах зөвлөл нь “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ын 1.4-т заасан “Сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгоно” гэсэн заалтыг биелүүлж ажиллаагүй байна.

3.4 Түүнчлэн ЭМЯ-ны арван долоон харъяа байгууллага, 21 аймгийн ЭМГ, тэдгээртэй хамтран ажилладаг харъяа байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд дэмжлэг тусалцаа, арга зүйн зөвлөгөө, илтгэл хичээл заах, мэдлэг мэдээлэл түгээх мэтээр салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан ажиллажээ.

3.5 3Г-ын 2012 оны 123 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар ЭМДС-ийн зөвлөлийн ажиллах журмыг баталжээ.

3.6 ЭМДС-ийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд ЭМЯ-аас дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь ЭМДС-ийн зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар заалтын 3.1.2-т заасан “Сангийн хөрөнгийн орлого, зарлагын байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх” гэсэн заалтыг биелүүлж ажиллаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ЭМДС-ийн үйл ажиллагааны хүрээнд зургаан үйл ажиллагааны 60 хувийн санхүүжилтийг олгож тэдгээр байгууллагуудаас 2014 оны 05 сарын 30-ны дотор гүйцэтгэлийн тайлан авахаар 230.4 сая төгрөгийн авлага үүсгэн гэрээ байгуулжээ.
2. ЭМДС-ийн 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн тодотгол хийх болсонтой холбогдуулан үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс 195.4 сая төгрөгийн нийт 14 арга хэмжээг хасжээ.
3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт зарцуулах хөрөнгөнөөс 21 аймагт хуваарлах санхүүжилтийн 60 хувь буюу 374.2 сая төгрөгийг олгож, 530 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.
4. 2013 оны төлөвлөгөөнөөс хасагдсан 18 үйл ажиллагааны санхүүжилтийг “Залуус-21” Алкоголгүй диско клуб байгуулахад зориулсан бөгөөд “Залуус-21” төвийг байгуулах, тохижуулах, хөрөнгө эд хогшил авах ажилд 124.5 сая төгрөг зарцуулсан байна.
5. Эрүүл мэндийн салбарын багц хуулийн үзэл баримтлалыг сурталчилах, хууль батлуулахад УИХ-ын гишүүдээс дэмжлэг авахад зориулан сангаас хөрөнгө гаргажээ.
6. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 162 дугаар тушаалын дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хамтран ажиллах төрийн бус байгууллагуудыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ЭМДС-ийн удирдах зөвлөл нь “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ын 1.4 дүгээр заалтыг биелүүлж ажиллаагүй байна.
7. ЭМДС-ийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд ЭМЯ-аас дотоод хяналт хийгдээгүй байна.
8. Төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлуудын чанар, үр дүн хангалтгүй хийгдэж, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах эрсдэлтэй байна.



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136, Утас: 7012-8801,
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
http://www.chd.moh.mn

2014.06.30 № 555
тантай 2014.06.16 -ны № 2/3384 -Т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР А.ЗАНГАД ТАНАА**

Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааны
гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж,
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Хуульд заасны дагуу гүйцэтгэлийн аудит, түүний
тайлангийн төсөлд өгөх саналыг хавсралт (1 хуудас)-аар
хүргүүлж байна.

Хувийг: Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга А.Эрдэнэтуяад

ЗАХИРАЛ  Ч.БАТ-ЭРДЭНЭ



ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТЭД ӨГӨХ ТАЙЛБАР

1. ЭМДС-гийн 2013 оны төлөвлөгөөний 6 үйл ажиллагаанд нь авлага үүсгэсэн нь Монгол Улсын эдийн засгийн хямралтай байснаас үүдэн Сангийн яамнаас төлөвлөгдсөн үйл ажиллагааны санхүүжилтийн эрхийг цаг хугацаанд нь нээж өгөөгүй. 2013 оны 12 сарын 23-нд зарим арга хэмжээний санхүүжилтийн эрхийг нээснээр энэхүү зургаан үйл ажиллагааны 60 хувийг олгож, 2014 онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан авлага үүсгэсэн болно.
2. Төсвийн тодотгол хийх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, ЭМДС-ийн зөвлөлийн гишүүдийн саналыг авч нийт 195.4 сая төгрөгийн 14 арга хэмжээг хассан. /ЭМС-ын 2013 оны 422 дугаар тушаал/
3. Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хуваарилах санхүүжилтийн 530 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон нь Монгол Улсын орлого бүрдүүлэлт биеллээгүйгээс ЭМДС-гийн санхүүжилтийг Сангийн яам дутуу олгосонтой холбоотой болно.
4. ЭМДС-гийн хөрөнгөөр “Залуус-21” Алкоголгүй диско клуб байгуулах үйл ажиллагааны санхүүжилт Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль, Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулахаар санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч байгууллагын хооронд гэрээ хийгдсэн. Санхүүжилт нь архины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж тэдний эрүүл мэндийг хамгаалах, уламжлалт ёс заншлаа дэлгэрүүлэх, харилцааны болон зан үйлийн зөв хэвшил олгох олон талт нийгмийн ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн боловсрол олгох ажилд зарцуулагдахаар төлөвлөгдсөнийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага хөрөнгө бүрдүүлж, бидэнд үнэн зөвөөр тайлагнаагүй байна.
5. Цаашид бид төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг чанартай, үр дүнтэй, хуулийн хүрээнд зохион байгуулж, зориулалт бусаар зарцуулах, эрсдэлд хүргэхгүйгээр ажиллах болно.

ЗӨВЛӨМЖИД ӨГӨХ САНАЛ:

1. Монгол Улсын Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль, ЭМДС-ийн дүрэмд нийцүүлэн ЭМДС-ийн үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээнүүдийг санхүүжүүлэн, хэрэгжүүлж ажиллана.
2. ЭМДС-ийн Зөвлөл нь Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль болон Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ийг мөрдөж ажиллана.
3. ЭМДС-ийн үйл ажиллагаанд ЭМЯ-наас явцын хяналт хийж ажиллах болно.
4. ЭМДС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хууль болон ЭМДС-ийн дүрэмд заасны дагуу зарцуулан ажиллана.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. ЭМСайд Н.Удвалд:

1. Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөлтийг баталж байх.
2. Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”- ийг мөрдөж ажиллах.
3. Эрүүл мэндийн яамнаас орон нутагт шилжүүлэн зарцуулах Эрүүл мэндийн тусгай сангийн төлөвлөгөөг тусгай сангийн журманд нийцүүлж гэрээний хугацаанд нь олгож төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх боломжоор хангах.
4. Төлөвлөгдсөн ажлыг бүрэн хийж, шаардлагатай арга хэмжээг цаг тухай бүрт авч, холбогдох дээд шатны байгууллагадаа тавьж шийдвэрлүүлэх.
5. Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсүгэй.

4. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хамжээ авч, үр дүнг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн сайд, Хууль зүйн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга нарт зөвлөсүгэй.

5. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД